



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/82

Мөрөн сум

Хорио цээрийн дэглэмийг цуцалж
хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Бүрээт 3-р багийн нутаг "Бага чандмань"-д малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдож сүүлийн мал эдгэсэнээс хойш мал нэмэгдэж өвчлөөгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалтын бүсэд байгаа малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, халдваргүйтгэл хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Т.Жавхлантөгс), Зон Дэм ХХК-МЭҮН-н малын эмч (Д.Дэмбэрэлваанчиг) нарт даалгасугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

